

“МОНГОЛ КООСЭН” ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИЙН ТЕХНОЛОГИ НЭВТРҮҮЛЭХ ТӨВИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар “Монгол Коосэн” Технологийн коллежийн /цаашид “Сургууль” гэнэ/ Технологи нэвтрүүлэх төвийн (Цаашид “Төв” гэнэ) статус, үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалттай холбогдсон харилцааг зохицуулна.

Хоёр. Төвийн зорилго

2.1. Төвийн үндсэн үйл ажиллагаа нь технологи нэвтрүүлэх, инновацийг хөгжүүлэх, оюуны өмчийн талаар зөвлөх, сургалт явуулах, сургуулийн судалгааны үр дүнг нийгэмд дэлгэрүүлэхийн зэрэгцээ, төрийн байгууллага, хувийн хэвшил болон олон нийтийн байгууллагатай хэрэгжүүлэх судалгаа шинжилгээний хамтын ажиллагааг дэмжихэд чиглэнэ.

Эдгээр үйл ажиллагаагаар сургуулийн төсвийн орлогын шинэ эх үүсвэр бий болгон, улмаар улс орон, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулан, цаашилбал глобал зах зээлд оролцох үндсэн зорилготой болно.

Гурав. Үйл ажиллагаа

Төв нь дээрх зорилгод нийцсэн дараах үндсэн үйл ажиллагааг явуулна. Үүнд:

- 3.1. Сургуулийн инновацийг хөгжүүлэх, менежментийн үндсэн чиглэл, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх;
- 3.2. Сургуульд шинэ технологи, ноу-хау нэвтрүүлэх, оюуны өмчийн бүртгэл хийлгэх, дэмжих;
- 3.3. Сургуулийн багш, ажилтан, судлаач, оюутанд инновацийн талаар зөвлөгөө өгөх, сургалт явуулах;
- 3.4. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллага, тэнхим, багш, оюутантай хамтарсан судалгаа, төсөл хийх;
- 3.5. Бэлэн технологийг нутагшуулах, судалгаа хийх;
- 3.6. Сургуулийн сургалтын чанарыг сайжруулах, инноваци, технологийн гарааны компани байгуулахад шаардлагатай мэргэжилтнийг бэлтгэх, бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх.
- 3.7. Төвийн зорилгод нийцсэн болон сургуулийн удирдлагаас үүрэг болгосон бусад үйл ажиллагаа;

Дөрөв. Зохион байгуулалт

4.1. Төв нь дараах ажилтантай байна. Үүнд:

4.1.1. Төвийн өдөр тутмын үйл ажиллагааг нэгтгэн удирдах Төвийн эрхлэгч. Төвийн эрхлэгчийг “Монгол Коосэн” Технологийн коллежийн захирал томилно.

4.1.2. Төвийн менежер

4.1.3. Тус Төв нь хамтран ажиллагч байгууллага, олон улсын, олон нийтийн байгууллагын хандив, хөрөнгөөр дараах мэргэжилтэн, ажилтныг ажиллуулж болно.

Үүнд:

- Зөвлөх

- “Монгол Коосэн” Технологийн коллежийн профессор, багш ажилтны статус бүхий ажилтан

- Координатор

4.1.4. Тус Төв нь гадаад, дотоодод тус төвийг төлөөлөх эрх бүхий төлөөлөгч хувь хүн, хуулийн этгээдтэй байж болно. Тэдний үйл ажиллагааны хүрээ, шаардагдах зардал, урамшуулал зэргийг харилцан гэрээгээр зохицуулна.

4.1.5. Бусад шаардлагатай гэрээт мэргэжилтэн, ажилтан.

Тав. Төвийн санхүүжилт

Төв нь үйл ажиллагаагаа тогвортой явуулахын тулд дараах орлогын эх үүсвэрээс санхүүжинэ:

5.1. Сургуулийн төсөв

5.2. Олон нийт, олон улсын байгууллага, хувийн хэвшлийн хамтарсан төсөл, хөрөнгө оруулалт, грант, тусламж, хандив.

Зургаа. Бусад зүйл

6.1. Энэхүү журамтай холбоотой гарсан маргаан, зөрчлийг “Монгол Коосэн” Технологийн коллежийн захиргаанд хүсэлт гарган шийдвэрлүүлнэ.

6.2. Энэ журам нь тус сургуулийн захирлын тушаалаар батлагдсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

6.3. Цаашдаа журамд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг “Монгол Коосэн” Технологийн коллежийн удирдлагатай санал солилцон, шийдвэрлэнэ.